



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 1/02

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь хэсэг, 16.5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хот болон Сөүл хотуудын хамтын ажиллагааны хүрээнд Сөүл хотын захиргааны 100 хувийн хөрөнгө оруулалтаар “Улаанбаатар хотын агаарын бохирдлын шалтгаан болон хил дамнасан агаарын бохирдлын найрлага тогтоох” хамтарсан судалгаа явуулах хамтран ажиллах гэрээний дагуу Солонгос улсаас нийлүүлсэн орчны агаарын чанарыг хэмжих суурин харуулыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

Д.Жаргалсайхан /ЗУХДАУТОГ/

Гишүүд:

Ц.Цолмон /ахлах мэргэжилтэн/

О.Алтангэрэл /мэргэжилтэн/

М.Отгонбаяр /мэргэжилтэн/


Д.Алтантуул /нярав/

Л.Нармандах /мэргэжилтэн/

Д.Санчирбаяр /мэргэжилтэн/

2. Суурин харуулын тоног төхөөрөмжүүдийг зохих журмын дагуу хүлээлцэж, үр дүнг 2016 оны 02 дугаар сарын 23-ны дотор албаны даргад танилцуулахыг ажлын хэсэг /Д.Санчирбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Ч.БАТСАЙХАН